

Хайраар холбогдсон үе үеийнхэн

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын  
Ахлагч Рассел М.Нелсон

Христийн Мэндэлсний Баярын үеэр хүлээн авдаг захидлууд нь дотно найз нөхөд болон хамаатан саднуудын маань талаарх дурсамжуудыг бидэнд сэргээн сануулдаг билээ. Зарим нэгэн нь эрхэм нандин гэр бүлийн зургуудыг багтаасан байдаг. Энд миний анхаарлыг гойд татсан нэгэн зураг байна л даа.

Энэ бол манай зээнцэр охины зураг. Би түүнийг “Хонгорхон Руби” хэмээн нэрлэе. Энэ зураг нь яг түүний насан дээрх ээжийг нь надад санагдуулж байна. Бичиг цаасан дундаасаа зээ охидын маань нэг болох “Хонгорхон Рубигийн” ээжийнх нь энэхүү зургийг би гаргаж ирэв.

“Хонгорхон Рубигийн” ээжийн энэхүү зургийг 29 жилийн өмнө би өөрөө дарсан билээ. Түүний нүд нь одоо ч яг ийм цэнхэрхэн хэвээрээ байдаг юм. Охидын маань нэг болох “Хонгорхон Рубигийн” эмээ нь гэр бүлийн маань шинэхэн гишүүн болоод байсан хагас зууны өмнөх түүний нялх үеийн зураг нь эрхэм нандин дурсамжийг санаанд минь зурсхийн орууллаа. Одоо тэрээр хүндэтгэл хүлээм сайхан эмээ, харин би “Хонгорхон Рубигийн” элэнц өвөө болжээ. (Би та нарт өөрийнхөө нялхын зургийг үзүүлэхгүй. Энэ нь илүүц буй за.) Эдгээр зурагнууд нь манай дөрвөн үеийг холбосон хайрыг харуулж байна.

Гэр бүлийнхээ гишүүн бүрийг хайрладаг хайрынхаа талаар бодохдоо би Тэнгэрлэг Эцэгийнхээ хүүхдүүдээ хайрлах хайрыг бага ч гэсэн мэдэрдэг юм. Дэлхий дахинд гэр бүлүүд халдлагын дор байгаа хэдий ч Бүтээгчийн хүүхдүүдийнхээ мөнхийн хувь тавиланд зориулсан төлөвлөгөөний төв нь гэр бүл мөн гэсэн энэхүү үнэнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм тунхагласаар, сурталчилсаар, хамгаалсаар байна. Гэр бүл *Дэлхий дахинд өргөх Тунхаг* болон гэр бүлийн түүхийн ажлууд нь Сүм гэр бүлийн нандин зохион байгуулалтад хэрхэн тус нэмэр болж найдвар төрүүлдгийг харуулах нотолгоо юм.

Хүүхдүүдээ хайрлах Бурханы хайр хязгааргүйг бид заадаг. Арьс өнгө, яс үндэс, хүйснээс хамааралгүй Тэр бүгдийг нь хайрладаг.<sup>1</sup> Тэрээр эхлэлээс үүнчлэн хийсээр ирсэн бөгөөд үргэлжлүүлэх ч болно. Бүх хүмүүс гэр бүлээрээ мөнхийн өргөмжлөлийг хүлээн авахыг Тэрээр урин хүсэмжилдэг билээ. Түүний ажил мөн алдар суу нь үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг Өөрийн хүүхдүүддээ тохиолгон авчрах юм.<sup>2</sup> “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.”<sup>3</sup>

Хайрт Хүүгийнх нь Цагаатгал Эцэгийн хоёр зорилго биелэгдэх боломжийг буй болгосон. Цагаатгалгүйгээр үхэшгүй байдал гэж үгүй. Цагаатгалгүйгээр Эцэгийн оршихуйд эргэн очих боломжгүй бөгөөд гэр бүлийн холбоо булшинд орсноор төгсгөл болох байсан юм.

Бурханы мөнхийн хууль зарлигуудыг дуулгавартай дагадаг Түүний хүүхэд бүр Цагаатгалын улмаас ирдэг эдгээр төгс адислалуудыг ухааран ойлгож чадна. Олон

зууны туршид Түүний олон хүүхэд сайн мэдээний адислалыг хүртэх боломжтой байсан ч тэднээс илүү олон хүнд тийм боломж олдоогүй билээ. Сайн мэдээний мэдлэггүйгээр нас барагсдад зориулан хийгдэх баптисмын ёслолыг дэлхий бүтээгдэхээс өмнө Тэнгэрлэг Эцэг маань бий болгосон юм.<sup>4</sup> Тэрээр тэдгээр хүүхдүүддээ ч мөн хайртай.

Тэр тэдэнд ч бас мөнхийн гэр бүлийн хэсэг байх арга замыг өгсөн юм. Энэ дэлхийд төрсөн хүн бүр үе залгамжилсан эцэг эхчүүдийн үр удам билээ. Өвөг дээдэстэйгээ холбогдох байгалаас заяасан хүсэл тэмүүлэл бидэнд буй. Наснаас үл хамааран энэ хүсэл бидний зүрхэнд оршсоор байдаг.

Гэр бүлийн мэдээллээ компьютерт оруулахад нь эмээдээ тусалж буй залуу эмэгтэйд эсвэл хүн амын тооллогын мэдээлэл дээр элэнц өвөөгийнхөө нэрийг харж буй залуу эрэгтэйд төрж буй, тэдний өвөг дээдэстэйгээ холбогдох сүнслэг холбоосын талаар бодоцгооё. Зүрх сэтгэлээ өвөг дээдэс рүүгээ эргүүлэхэд бидний дотор ямар нэг өөрчлөлт гардаг. Өөрсдийгөө ямар нэгэн агуу зүйлийн хэсэг нь юм гэдгээ бид мэдэрдэг. Бидний ураг төрөлтэйгөө холбоотой байх төрөлхийн хүсэл маань ариун сүмийн нандин ёслолуудаар дамжуулан өвөг дээдэстэйгээ холбогдох үед биелэгддэг.

Энэ ажил чухал ач холбогдолтой учраас, өмнө нь хэзээ ч байгаагүйгээр гэр бүлийн түүхийн судалгааны ажлыг сүмд зохион байгуулж, ариун сүмүүдийг хүмүүст<sup>5</sup> илүү ойртуулан барьж байна. Ариун сүмийн ёслолуудад зориулан нэрсийг хайж олон, бэлтгэх аргууд нь илүү сайжирсан. 2005 оны Чуулган дээр гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажил нэг алхам ахин урагшилж байгааг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли зарласан билээ. Тэрээр, “Ариун сүмийн үйл ажиллагаануудын хамгийн хэцүү зүйлсийн нэг нь бид илүү олон ариун сүмүүдийг дэлхий даяар барих тусам бусдын өмнөөс үйлддэг ёслолууд нь давхардан гүйцэтгэгдэх асуудал байлаа. . . . Тиймээс бид хэсэг хугацааны турш энэ хэцүү ажлыг хариуцан ажилласны үр дүнд. . . шийдэл нь компьютерийн нарийн технологи ажлын үр дүнд буй болов.”<sup>6</sup> Тэр цагаас хойш зөвхөн давхардсан асуудал багасаад зогсоогүй ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажил нь бараг бүх гишүүд оролцож болохуйц амар хялбар болсон билээ. Энэхүү нандин ажлыг зөвхөн мэргэжилтнүүд хийдэг цаг аль хэдийн ард хоцорчээ. Та ямар ч нөхцөлд байлаа гэсэн, гэр бүлийн түүхийг яг одоо амьдралынхаа нэг хэсэг болгож болно. Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд гэр бүлийн мод зурж болно. Өсвөр насныхан нас барагсдын өмнөөс баптисм хүртэх ажилд оролцож болно. Тэд мөн ахмад үеийнхэнд компьютер дээр ажиллахад нь тусалж чадна. Эцэг эхчүүд амьдралынхаа түүхүүдийг үр хүүхдүүддээ ярьж өгч болно. Насанд хүрсэн зохистой гишүүд маань ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байснаар өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэж чадна.

Бошиглогч Иосеф Смит, “Энэ дэлхий дээр Бурханы бидэнд хүлээлгэсэн хамгийн агуу хариуцлага бол нас барагсдын мэдээллүүдийг эрэлхийлэх явдал юм”<sup>7</sup> хэмээн хэлсэн. Шинэ технологи нь энэхүү хариуцлагыг биелүүлэхэд өмнөх үеэс илүү хялбар болгож байна. Одоогоор ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажил нь “New FamilySearch”<sup>8</sup> систем дээр хийгдэж байна. Интернетэд суурилсан энэхүү систем нь гишүүдэд өвөг дээдсээ олж мэдэн ямар ёслолын ажлууд хийгдэх хэрэгтэйг тодорхойлоод, тэдний нэрсийг ариун сүмд бэлтгэхэд нь тусалдаг юм. Энэ системд гэрээсээ, Гэр бүлийн Түүхийн Төвөөс<sup>9</sup>, эсвэл интернеттэй хаанаас ч нэвтэрч болно. Үе шат нь гүйцэтгэхэд маш хялбархан юм.<sup>10</sup>

Эхлээд та ариун сүмийн ажлыг тэдний төлөө хийхийг хүсэж буй хувь хүмүүсийг олж тогтоо.

Тэгээд та Гэр бүлийн ёслолын хүсэлтийн маягтыг хэвлэж гаргана. Энэ бичиг нь ариун сүмд шаардлагатай мэдээллийг өгөхөөс гадна компьютерийн дискийг аваачих шаардлагагүй болгодог.

Гэр бүлийн ёслолын хүсэлтийн маягтаас ёслолын картууд хэвлэгдэн гардаг. Ёслол гүйцэтгэгдсэний дараагаар энэ нь тэр өдөртөө л New FamilySearch-д бүртгэгддэг. Тэгвэл одоо, компьютергүй эсвэл энэ технологийг ашиглахгүй байхыг илүүд үзэж байгаа хүмүүс яах вэ? Бүү санаа зов! Алхам алхамаар нь хий. Гэртээ эхлүүл. Ерөнхийлөгч Боид К.Пакерийн зөвлөсний дагуу хоосон цаасан хайрцгаас эхэл.<sup>11</sup> Гэр бүл болон өөрийнхөө талаарх чухал мэдээллүүдийг тэр хайрцагтаа хий. Гэр бүлийнхээ бусад хүмүүсээс авсан мэдээллээ нэмээд л бай. Тэгээд салбар эсвэл тойргийнхоо гэр бүлийн түүхийн зөвлөхөөс тусламж аваарай. New FamilySearch системд зөвлөхүүд ариун сүмд нэр бэлтгэх болон бүхий л шаардлагатай компьютерийн үйлдлүүдийг таны өмнөөс гүйцэтгэх боломжтой. Дэлхий даяар 60,000 орчим зөвлөх үйлчилж байна. Танай тойрог, салбарын зөвлөх танд сайн туслалцаа үзүүлж чадна.

New FamilySearch систем нь бид бүгдээрээ ажиллаж чадах нийтлэг ургийн бичгийг бүтээхийн төлөө ажилласнаар гэр бүлийн түүхийн ажлын үйл явцыг өөрчилсөн юм. Өмнө нь хүн бүр тусдаа өөрийнхөө гэр бүлийн түүхийг хөтлөн ажилладаг байлаа. Гэр бүлийнх нь өөр нэг гишүүн юу хийж байгааг мэдэлгүйгээр ажиллах нь олонтоо тохиолддог байв. Харин одоо гэр бүлийнхээ модыг хөгжүүлэхийн төлөө хүн бүр бусадтайгаа хамтран ажилласнаар мэдээллээ нэмэрлэж чадна.

Хэдийгээр New FamilySearch систем урагш ахисан агуу том алхам ч гэсэн, энэ нь нэг л алхам юм. Цаана нь хийх ажил их байна. Систем маань хэдэн арван жилийн туршид янз бүрийн хүмүүсээс ирж, сүмд хураагдсан мэдээллийг үзэх боломжийг олгодог тул өмнө нь мэдэгдэж байгаагүй алдаа, эсвэл давхар оруулсан мэдээллийг New FamilySearch ил гаргах болно. Ялангуяа эртний анхдагч өвөг дээдэстэй хүмүүст энэхүү хэрэгсэл нь ихээхэн ашигтай. Давхар эсвэл алдаатай оруулсан мэдээллийг засах хэрэгтэй бөгөөд өөрийн гэр бүлийн төлөө ажиллаж буй хүнээс өөр хэн ч үүнийг илүү сайнаар хийж чадахгүй.

Эдгээр сорилтыг даван туулахад та шантарч магадгүй. Таны асуудлуудыг маш сайн ойлгож байгаа гэдэгт итгээрэй. Сүнслэг удирдамжаар удирдагдсан Ерөнхийлөгч Томас С.Монсоны удирдлаган дор эдгээр асуудлуудыг шийдэхэд тань туслахаар Сүм хичээнгүйлэн ажиллаж байна. Бурханы бүх хүүхдүүдэд гэр бүлийнх нь модыг зохион байгуулахын тулд бид бүгдээрээ хамт зүтгэж байна. Энэ бол агуу их шагналтай асар их хүчин чармайлт билээ.

Энэ бол баяр баясгалантай ажил. Өөрсдийн өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмийн ажил хийж буй энэ шинэ хөрвөгчдийн зургийг хар л даа. Сан Сальвадорын Эл Сальвадор гадасны эдгээр эрхэм Гэгээнтнүүд Гватемал хотын Ариун сүмд анх удаагаа орж буй нь энэ ажээ. Тэд тус бүртээ өмнөөс нь баптисм хүртсэн нас барсан төрөл төрөгсөдийнхөө нэртэй ариун сүмийн картыг барьсан зогсож байна. Сүмийн гэр бүлийн түүхийн ажил амжилттай байхад санваартны чиглүүлэл болон удирдлага нэн чухал. Энэ ариун нандин ажлын үндэс суурь болсон сургаалыг

удирдагчид зааж, гэрчилдэг.<sup>12</sup> Тэд гишүүдэд дуудлагат ажил өгч, үүнийгээ биелүүлэхэд нь удирдамж заавраар хангадаг юм.<sup>13</sup> Тэд ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажлыг тухайн тойргийнх нь сүнслэг байдлыг нэмэгдүүлэх, шинэ гишүүдийн сүнслэг үндэс суурийг бэхжүүлж, бүх гишүүдийн амьдралыг адислах арга зам мөн гэж үздэг.

Ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажлууд нь сүнсний дэлхий дэх хүмүүсийг адислах хүчтэйгээс гадна амьд хүмүүсийг ч бас адислах хүчтэй. Энэ үйлсэд хүчин зүтгэж буй тэднийг энэхүү ажил ариусган цэвэршүүлэх нөлөөтэй. Үнэхээр тэд гэр бүлүүдийнхээ өргөмжлөлд хүрэхэд тусалж байгаа юм.

Бүхнийг Чадагч Бурханы оршихуйд төрөл төрөгсдийнхөө хамт амьдарч чадах юм бол бид өргөмжлөгдөж чадна. Бошиглогч Иосеф Смит бидний үүрэг хариуцлагыг урьдаас харсан: “Эзэний агуу өдөр ойрхон байна,” “Тиймийн тул, бид Сүм болон хүмүүсийн хувьд, мөн Хожмын Үеийн Гэгээнтүүдийн хувьд Их Эзэнд зөв шударга байдалд өргөл өргөцгөөе; түүний ариун сүмийг дуусгахад хүлээн зөвшөөрөх бүх зүйлсээс зохистой нь болох бидний нас барагсдын цэдгүүдийг агуулагч номыг тэнд байлгацгаая”<sup>14</sup> хэмээн тэр хэлсэн.

Тэрхүү цэдгийг бэлтгэх нь бидний хувийн болоод хамтын хариуцлага юм. Бид хамтдаа ажилласнаар үүнийг Их Эзэн хүлээн зөвшөөрөхүйц зохистой болгож чадна. Хэрэв нас барсан өвөг дээдэс маань хүлээн зөвшөөрвөл, тэдгээр ёслолуудыг өмнөөс нь гүйцэтгэх боломжыг тэр цэдэг олгодог. Тэдгээр ёслолууд нь хөшигний цаана буй боолчлогсод эрх чөлөөг авчирч чадна.<sup>15</sup>

Бидний хүүхдүүд, ач зээ нар, “Хонгорхон Руби” болон бүх зээнцрүүд маань хайраараа холбогдсон юм. Тэд өвөг дээдэстэйгээ ч мөн хайраар холбогдсон. Тэрхүү холбоос нь ариун ёслолуудаар гагнагдсан бөгөөд бидний гэр бүлүүдийг өргөмжлөл өөд хөтөлдөг.<sup>16</sup> Энэхүү ариун зорилгыг бидний хүн нэг бүр ухаарах болтугай хэмээн би Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.

ЭШЛЭЛ

1. 1 Коринт 12:13; Галат 3:28; 2 Нифай 26:33-ыг үз.

2. Мосе 1:39-ийг үз.

3. Иохан 3:16.

4. Сургаал ба Гэрээ 124:33-ыг үз.

5. Дэлхий даяар, сүмийн гишүүдийн 83 хувь нь ариун сүмээс 320 километрээс дотогш зайд амьдардаг гэж Ерөнхийлөгч Томас С.Монсон саяхан хэлжээ (“Чуулганд тавтай морил,” *Луахона*, 2009 оны арваннэгдүгээр сар, 4-ийг үз.)

6. Гордон Б.Хинкли, “Opening Remarks,” *Ensign*, 2005 оны арваннэгдүгээр сар, 5-6.

7. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 475.

8. Одоогоор англи, испани, португаль, франц, герман, япон, хятад, солонгос хэлээр ашиглах боломжтой.

9. Дэлхий даяар 4000 гаруй Гэр бүлийн Түүхийн төв ажиллаж байна.

10. Хэрэв та компьютертэй бол [new.familysearch.org](http://new.familysearch.org). хаягаар орж үзнэ үү. Эхний удаа бүртгүүлэхдээ та гишүүнчлэлийн дугаар болон гишүүний баталгаа хийлгэсэн он сар өдрөө мэдэж байх хэрэгтэй. Та энэ мэдээллийг тойрог, салбарынхаа бичиг хэргийн ажилтнаас авч болно. Системд нэвтэрснийхээ дараа өвөг дээдсийн тань нэрс бүртгэгдсэн эсэхийг мөн ариун сүмийн ямар ёслолууд шаардлагатайг шалгаж болно. Мэдээлэл нь тодорхойгүй өвөг дээдсийнхээ талаарх мэдээллийг олж гэр бүлийнхээ цэдэгт нэмэх хэрэгтэй. Гэр бүлийн ёслолын хүсэлтийн маягтийг хэвлэж ариун сүмд авч явснаар шаардлагатай ёслолуудыг гүйцэтгэх боломжтой болно.

11. Боид К.Пакер, “Your Family History: Getting Started,” *Лиакхона*, 2003 оны наймдугаар сар, 12-17-г үз.

12. Гадасны ерөнхийлөгчийн шууд удирдлаган дор нэг эсвэл түүнээс дээш тооны дээд зөвлөлийн гишүүд гадасны ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлыг хариуцан ажилладаг. Тойрог эсвэл салбарын түвшинд бол дээд санваартны хэсгийн удирдагч эсвэл ахлагчдын чуулгын ерөнхийлөгч удирддаг. Гэр бүлийн түүхийн зөвлөхүүд болон санваартан удирдагчдад үүргээ биелүүлэхэд нь туслах олон хэвлэмэл болон онлайн эх сурвалжууд байдаг.

13. Шинэ эх сурвалжууд дотор *Member’s Guide to Temple and Family History Work*, (зүйлийн дугаар 36795) болон *Instructor’s Guide* (зүйлийн дугаар 36795) мөн DVD-ний хамт байгаа. Эдгээр удирдамжуудыг онлайнаар үзэх буюу татаж авч болохоос гадна [lds.org](http://lds.org) хаягаар орж Хангамжийн төвөөр дамжуулан захиалах боломжтой.

14. Сургаал ба Гэрээ 128:24.

15. Исаиа 61:1; Лук 4:18; Сургаал ба Гэрээ 138:18, 31, 42-ыг үз.

16. Сургаал ба Гэрээ 128:18-ыг үз.